ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/18 Сайншанд

Ахмадын сургаал алтнаас үнэтэй дэд
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Ахмадын сургаал алтнаас үнэтэй" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013036

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27 өдрийн
03/18 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

АХМАДЫН СУРГААЛ АЛТНААС ҮНЭТЭЙ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалт

1.2 Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13 ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтын 1, 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх

1.3 Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл

1.4 Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн 2.3.1, 5.1.4 дэх заалт

1.5 Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын өсөлт" заалтыг хэрэгжүүлэх.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага

Өнөө үед дэлхий нийтийн өмнө тулгарч байгаа нэг онцлог асуудал бол хүн амын насжилт юм. ДЭМБ-аас "Идэвхтэй урт наслалт"-ыг хүний амьдралын нэгэн үнэт баялаг гэж үзэж амьдралын чанарыг сайжруулах нь настай хүмүүсийн аюулгүй байдал, нийгмийн оролцоо, эрүүл мэндийн боломжийг нэмэгдүүлэх үйл явц мөн хэмээн тодорхойлсон байна.

Сэврэй сумын хэмжээнд хэмжээнд 60 дээш настай 181 ахмад байгаа нь сумын нийт хүн амын 9,7 хувийг эзэлж байна. Ахмад настны хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөр настнуудад эзлтэй уламжлалт зан заншил, нийгмийн харилцаа холбоог улам бэхжүүлэх, хувь хүний аюулгүй байдлыг хангах, гудамж талбай, зам, барилга байгууламжийг ахмад настанд эзлтэй хүртээмжтэйгээр тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн тохижуулах шаардлагатай байна.

Ахмад настнуудын эх орноо хөгжүүлэх, төр, нийгмийн ажил үйлсэд оролцож, хувь нэмрээ оруулах чин хүсэл, санал санаачилгыг төр, засагт уламжлан хүргэж, төр, нийгэм, ахмад, залуу, хойч үеийн алтан холбоог бэхжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 2021-2024 онд уг хөтөлбөрийг анхлан хэрэгжүүлснээр ахмадуудад зориулсан төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, эрүүл мэндийн тусламж, үзлэг оношилгоо, гэрийн асаргаа, сувилалд хамрагдах ахмадын тоо нэмэгдсэн. Мөн ахмадууд урлаг, спортоор идэвхтэй хичээллэж софт волейболыг суманд хөгжүүлж байна. Ахмадын бүжгийн тэмцээнд аймагтаа 3 дугаар байр эзэлсэн амжилт гаргасан. Тэтгэвэрт гарсан ахмадууд ахмадын холбоондоо элсэж, зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж нэгдэж байгаа зэрэг нь цаашид энэ хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ байгааг харуулж байна.

Гурав. Хамрах хүрээ. Энэхүү хөтөлбөрт тус сумын нийт ахмадууд хамрагдана.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго

Ахмад настнууд баялаг бүтээгч нийгмийн идэвхтэй эрүүл гишүүн байж, нийгмийн амьдралд тэгш оролцож, сэтгэл хангалуун өөдрөг амьдрах ээлтэй орчин бүрдүүлэх, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалах, ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяаг хойч үед үлгэр дуурайл болох үйлсийг дүрсжүүлэн хадгалах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах, тэдний хөгжих, боловсрох, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэх, залуу үеийнхэнд ахмадын эх оронч, хөдөлмөрч дайчин уламжлал, төрөө дээдлэх үзлийг өвлүүлэн ахмад, залуу үеийнхний алтан хэлхээг бэхжүүлэх, ахмадын хамгааллыг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ

5.1 Ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох үйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах, дүрсжүүлэх

5.2 Ахмадуудад үзүүлэх нийгэм, соёлын үйлчилгээг нэмэгдүүлэн “Ахмадын өргөө”-ний үйл ажиллагааг өргөжүүлэх

5.3 Ахмад настнуудад эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн үйлчилгээг хүргэх, нийгмийн хамгааллыг сайжруулах замаар зөв, урт наслалтыг дэмжих

Зургаа Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

6.1 Ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох үйл ажиллагааг олон талт хэлбэрээр зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах, дүрсжүүлэх

6.1.1 Сумын ахмад настай иргэдтэй ярилцлага хийж дүрсжүүлэх

6.1.2 Ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох үйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах чиглэлээр ахмадуудтай ярилцлага хийж “Хатан Сэврэйн мэдээ” сонинд нийтлэх

6.1.3 Ахмад настан нь ахмадуудын зөвлөх үйлчилгээнд хамрагдан, зорилтот бүлгийн иргэдэд амьдрах ухаан, аж ахуй эрхлэх болон бусад чиглэлийн танхимын, зайны, шавь сургалт явуулахыг дэмжиж ажиллах

6.1.4 Ахмад настнаас суралцах “Буурлаас үг сонс” контент хийх

6.1.5 Ахмадуудыг түшиглэн угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг сумын хэмжээнд сайжруулах, ураг удмын бичгээ хамгийн сайн хөтөлсөн ахмадуудыг алдаршуулах

6.1.6 Ахмад настныг хүндлэх, дэмжиж туслах эцэг, эхээ асран тэтгэх үр хүүхдийн үүрэг хариуцлагыг хүүхдэд бага наснаас нь ойлгуулах ажлыг сургууль цэцэрлэгээр дамжуулан зохион байгуулах

6.1.7 Ахмад залуучуудын дунд үндэсний уламжлалт, ардын наадам, соёлын арга хэмжээг зохион байгуулах

6.2 Ахмадуудад үзүүлэх нийгэм, соёлын үйлчилгээг нэмэгдүүлэн “Ахмадын өргөө”-ний үйл ажиллагааг өргөжүүлэх

6.2.1. Ахмадын өргөөний барилгын ажилд хяналт тавьж, чанартай сайн гүйцэтгүүлж, хүлээн авч, ашиглалтад оруулах

6.2.2 Ахмадын өргөөг шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, эд хөрөнгөөр хангах

6.2.3 Ахмадын өргөөг түшиглэн ахмад настанд цаг үеийн шаардлагаар зайлшгүй хэрэгцээтэй болж байгаа гар утас, компьютер, интернэт, шинэ дэвшилтэд технологи, тоног төхөөрөмж ашиглах төрөл бүрийн сургалтуудыг тэдний хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах

6.3 Ахмад настнуудад эрүүл мэнд, боловсрол, хөгжлийн үйлчилгээг хүргэх, нийгмийн хамгааллыг сайжруулах замаар зөв, урт наслалтыг дэмжих

6.3.1 Харах асрах хүнгүй амьдардаг ахмад настанд дэмжлэг туслалцаа үзүүлэх

6.3.2 Ахмад настны амьжиргааг дэмжих, ядуурлаас хамгаалах "Ахмаддаа тусалъя" аяныг жил бүр зохион байгуулж, уг үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

6.3.3 Ажил олгогч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настан /ажилтан/-г эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн хувьд бэлтгэж ажиллах

6.3.4 Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад тухайн баг, байгууллагаас дэмжлэг тусламж үзүүлэх

6.3.5 Ахмад настныг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шаардлагатай ахмадуудыг эмчилгээ, сувилгаанд хамруулах ажлыг эрүүл мэндийн төвөөр дамжуулан хэрэгжүүлэх

6.3.6 Хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмадуудын судалгааг жил бүр нарийвчлан гаргаж, хяналтад авах, гэрээр эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх

6.3.7 Ахмадын хээрийн сувиллын үйл ажиллагааг өргөжүүлж, жил бүр 30-аас дээш тооны ахмадуудыг сувилалд хамруулах

6.3.8 Ахмадуудыг нас, бие бялдрын онцлогт тохирсон сургалт, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнд хамруулах

6.3.9 Ахмадуудын дунд урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах, аймаг, улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг туслалцаа үзүүлэх

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

7.1. Ахмад настныг нас, хүйс, арьс өнгө, боловсрол, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, оюун ухаан, бие махбодын чадвараар ялгаварлан гадуурхагдахаас ангид байх нөхцөлийг бүрдүүлж, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалах, ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох үйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулахад чиглэгдэх

7.2 Ахмад настнууд нийгмийн бүхий л хүрээнд эрх тэгш боломжоор хангагдах

7.3 Салбар дундын хамтын ажиллагааг чухалчлах, аливаа бодлого, шийдвэр гаргах, төлөвлөн хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд тэдний оролцоог хангах

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт,удирдлага зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийг 2025-2028 онуудад хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

8.3 Орон нутгийн төсөв

8.4 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

8.5 Бусад эх үүсвэр

Хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, мэдээллээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг сумын Засаг даргын Тамгын газар хариуцан, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1 Ахмад настан 40 иргэнтэй ярилцлага хийж, дүрсжүүлэн, архив үүсгэн хадгалж, гэр бүл хойч үе, сум орон нутагт түгээн дэлгэрүүлсэн байна.

9.2 Ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох зүйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулсан байна.

9.3 Ахмадын өргөөний барилгыг ашиглалтад оруулж тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр тохижуулж тэдний хөгжих боломжийг бүрдүүлсэн байна.

9.4 Ахмадуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор урлаг, спортын төрөл бүрийн арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулсан байна.

9.5 Ахмад настны асаргаа сувилгаа, сэргээн засах үйлчилгээний хүртээмж сайжирч, ахмадуудад үзүүлэх нийгэм, соёлын үйлчилгээ өргөжин, ахмад настны аж байдал дээшилж, амьдрах орчин, нөхцөл сайжирсан байна.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Сумын Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгтгэн, сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
			2024	2025	2026	2027	2028
1	Сумын ахмад настай иргэдтэй ярилцлага хийж дүрсжүүлэх	тоо	4	10	10	10	10
2	“Хатан Сэврэйн мэдээ” сонинд нийтэлсэн ахмадуудын ярилцлага	тоо	1	3	3	3	3
3	Ахмад настны зөвлөх үйлчилгээнд хамрагдсан	тоо	2	2	2	2	2

	ахмадуудын тоог нэмэгдүүлэх						
4	“Буурлаас үг сонс”контентын хийх	тоо	0	8	8	8	8
5	Угийн бичиг хөтлөх, ургийн баяр зохиох, ургийн ном хэвлүүлсэн ахмадын тоог нэмэгдүүлэх	тоо	12	2	2	2	2
6	Үндэсний уламжлалт ардын наадмыг жил бүр зохион байгуулах	Тоо	0	1	1	1	1
7	Ахмадын өргөөг ашиглалтад оруулж, тохижуулах	Хувь	40	100	-	-	-
8	Ахмадуудад зориулсан сургалтын тоог нэмэгдүүлэх	тоо	3	5	5	5	5
9	“Ахмаддаа тусалъя” аяныг жил бүр зохион байгуулах	тоо	0	1	1	1	1
10	Гэрээр эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх ахмадын тоог нэмэгдүүлэх	тоо	96	100	100	100	100
11	Ахмадын хээрийн сувиллын үйл ажиллагааг өргөжүүлж, хамрагдах ахмадын тоог нэмэгдүүлэх	тоо	25	30	30	30	30
12	Дасгал хөдөлгөөн хийх өрөө тасалгаа, заалаар үнэгүй үйлчлэх үйлчилгээг нэмэгдүүлэх	тоо	2	4	4	4	4
13	Ахмадуудын дунд урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах	тоо	1	2	2	2	2
14	Аймаг, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг, үзүүлэх	тоо	2	4	4	5	5
15	Ахмадуудын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах	тоо	3	5	5	5	5

---000---

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
03/18 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт

АХМАДЫН СУРГААЛ АЛТНААС ҮНЭТЭЙ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: Б.Цэнгэл (Сумын ИТХ-ын төлөөлөгч, Нийгмийн бодлогын хөгжлийн хорооны гишүүн)

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

20 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Соёлын төвийн эрхлэгч

Сумын ахмадын хорооны дарга

Хүүхэд гэр бүлийн Нийгмийн ажилтан

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан

---000---